



# СОЁМБОМ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

# МЭДЭЭ

№221 /430/

2022.12.08

Цаг үе, үйл явдал

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ ЗАСГИЙН ГАЗАР, ХУУЛЬ, ХҮЧНИЙ БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГУУДАЙ УУЛЗАВ



Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх өнөөдөр 12.30 цагт Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга бригадын генерал С.Ганбямба, Монгол Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайхан, Тагнуулын ерөнхий газрын дарга хошууч генерал П.Одонбаатар, Авлигатай тэмцэх газрын дэд дарга, эрхэлсэн комиссар Г.Азжаргал, Цагдаагийн ерөнхий газрын дарга хошууч генерал Ж.Болд нарыг дуудаж уулзав.

Ард иргэд дөрвөн өдрийн турш төв талбайд жагсаал хийж байгаа ч Засгийн газар, хууль, хүчний байгууллагууд өнөөг хүртэл тодорхой арга хэмжээ авч, шийдвэрлэхгүй байгааг Ерөнхийлөгч буруушаав.

Тэрбээр нүүрсний хулгайчдын нэрийг зарлахгүй байгаа шалтгааныг тэднээс нэхэж, энэ хэрэгт нэр холбогдсон Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх асуудлыг Улсын Их Хуралд оруулах эрх хуулиар олгогдсоныг Улсын Ерөнхий прокурорт хатуу санууллаа. Хэрвээ асуудлыг шуурхай шийдвэрлэхгүй бол

холбогдох хууль тогтоомжуудад заасны дагуу Улсын Их Хурал, Засгийн газрын бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгож, ард түмэнд сонголт хийх эрхийг нь олгох цаг ойрхон байгааг анхааруулав.

Түүнчлэн Засгийн газрын төлөөллийг төв талбайд очиж жагсагч иргэдтэй уулзан, хийж байгаа ажлаа ил тод ярихыг шаардав.

Уулзалтад Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга Ж.Энхбаяр, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар нар байлцав.

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-16	-27


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
38	23

### ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.443	3.446
EUR	3.632	3.650
CNY	490	494
RUB	52.20	53.50
JPY	25.20	25.60
KRW	2.63	2.65

### ЗУРХАЙ



2022.12.08 / ПҮРЭВ ГАРАГ /  
БИЛГИЙН ТООЛЛЫН 15

**ӨВЛИЙН ТЭРГҮҮН ЦАГААГЧИН  
ГАХАЙ САР  
ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ  
ХӨХӨГЧИН ХОНЬ ӨДӨР**

**Үс засуулбал:**  
Өлзийтэй сайн  
**НАРАН УРГАХ, ШИНГЭХ:**  
08.27-17.00  
**Барилдлага:**  
Идэр  
**Шүтэн барилдлага:**  
Тийн мэдэхүй

## БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ, УМАРД АТЛАНТЫН ГЭРЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ДЭЭД ШТАБ ХООРОНДЫН ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТ АМЖИЛТТАЙ БОЛЛОО



Монгол Улсын Батлан хамгаалах яам, Умард Атлантын Гэрээний Байгууллагын Дээд штаб хоорондын зөвлөлдөх уулзалт энэ сарын 1-2-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа.

Зөвлөлдөх уулзалтад УАГБ-ын Олон улсын цэргийн штабын Хамтын аюулгүй байдлын газрын дарга хошууч генерал Францеско Диелла тэргүүтэй төлөөлөгчид болон Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар, Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга хурандаа Ч.Гандирваа тэргүүтэй Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний

Жанжин штабын төлөөлөгчид оролцлоо.

Зөвлөлдөх уулзалтын эхэнд Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар УАГБ-ын төлөөлөгчдийн тэргүүн хошууч генерал Францеско Диеллаг хүндэтгэн хүлээн авч уулзав. Тэрбээр төлөөлөгчдийг Монгол Улсад тавтай морилохыг хүсээд, хүрэлцэн ирсэнд сэтгэл өндөр байгаагаа илэрхийлсэн юм. Мөн Монгол Улсын Батлан хамгаалах бодлого, зорилт, үйл ажиллагааны талаар товч танилцуулж, зөвлөлдөх уулзалтад амжилт хүслээ.

Зөвлөлдөх уулзалтын зорилго нь Монгол

Улсын Батлан хамгаалах яам, УАГБ-ын харилцаа, цэргийн хамтын ажиллагааны уламжлалыг хадгалж, хамтын ажиллагааны өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагыг тодорхойлж, батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны талаар харилцан мэдээлэл хийж, хамтын ажиллагааны санал солилцоход оршиж байв.

Энэ хүрээнд талууд хамтын ажиллагааны тодорхой, үр дүнтэй санал, санаачилгуудыг дэвшүүлсэн бөгөөд цаашид хэрэгжилтэд анхаарч, идэвхтэй хамтарч ажиллахаар тогтов.

Гэрэл зургийг Х.УНДАРМАА

Тухайн өдөр бар, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Эл өдөр санасан хэрэг түргэн бүтнэ. Бүтээл үйлдэх, тус чухалчлах, хэл ам дарах, башир, хатуу, түргэн үйлнээ сайн, эм засал хийлгэх, авшиг авах, бэрийн үйл, дайсныг дарахад болон хуран чуулах, үс угаахад сайн. Зүүн нүд татвал хувцас олодо, баруун нүд татвал тэмцэл болох, баруун чих хангинавал сайн, зүүн нь хангинавал өчүүхэн нэгнийг үзэх, тагнай загатнах, бие татвал үзэсгэлэн болох, хөлийн шөрмөс татвал үг, асуулт болно.

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 651,580,880

Эдгэрсэн

Нийт: 627,892,375

Нас барсан

Нийт: 6,651,983

Цаг үе, үйл явдал

“ӨӨРТӨӨ ИТГЭЖ, БУСДЫГ МАНЛАЙЛАХ ЧАДВАР”-ААР ЛЕКЦ ТАВИЛАА



Төв аймгийн Залуучуудын холбооноос "Эр цэргийн үнэ цэн", "Өөртөө итгэж бусдыг манлайлах чадвар", "Спортын хүмүүжил, тамирчин хүний сэтгэл зүй" гэсэн сэдвээр Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн хугацаат цэргийн алба хаагчдад лекц уншиж, яриа таниулга хийлээ.

Дээрх илтгэлүүдийг гэр бүл судлаач Р.Мөнхцэцэг, илтгэгч Ц.Баяржаргал, Г.Ганзориг нар хийсэн бөгөөд энэ үеэр байлдагч Ж.Энхмөнх цэргийн албанд ирээд өөртөө итгэлтэй зөв хүн болж төлөвшин, хүсэл мөрөөдөлтэй, зорилготой болсон талаараа илэрхийлсэн юм.

Уг арга хэмжээний төгсгөлд нийт бие бүрэлдэхүүн кино найруулагч Ч.Оюундэлгэрийн бүтээл "Дайнд мордсон охид" баримтад кино болон ЦДБЭЧ-ын ахмад уран бүтээлч Б.Баяржаргалын ая дууны мэндчилгээг сонордлоо.

Хошууч Д.ДОЛГОРЖАВ



Цахим шууданд

БИДНИЙ БАХАРХАЛ ТӨСЛИЙН ХҮРЭЭНД...



Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Монгол цэргийн нэгдсэн холбоо, Монгол хурандаа нийгэмлэг хамтран хүүхэд залуучуудад эх оронч үзэл, ёс зүй, ухамсрыг төлөвшүүлэх, Эх орноороо бахархах, хайрлан хамгаалах үйл ажиллагааг сурталчлан, дэлгэрүүлэх, ахмад үеийн хөдөлмөрч, дайчин замнал, үнэт өвийг, залуу хойч үеийнхэнд зааж сургах, өвлүүлэн үлдээх зорилгоор "БИДНИЙ БАХАРХАЛ" төслийг Төв аймагт амжилттай зохион байгуулав.

Арга хэмжээнд Төв аймгийн ЗДТГ-ын дарга М.Отгонбат, Монгол хурандаа нийгэмлэгийн гүйцэтгэх захирал, доктор профессор хурандаа Д.Баярхүү болон удирдах зөвлөлийн гишүүд, Төв аймгийн төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдлагууд оролцож "Тусгаар тогтнолын үнэ цэнэ", "Залуучуудын эх оронч үзэл, ахмад үеийн дайчин уламжлал" сэдвүүдээр тус тус яриа хэлэлцүүлгийг өрнүүллээ.

Тус арга хэмжээнд Зуунмод сумын Ерөнхий боловсролын сургуулиудын сурагчид болон хугацаат цэргийн алба хаагчдыг урин оролцуулж нэгтгэлийн үйл ажиллагааг хүүхэд залуучуудад сурталчилсан олон үйл ажиллагааг зохион байгуулсан юм.

Хошууч Д.ДОЛГОРЖАВ



Зэвсэгт хүчний 232 дугаар ангийн нээлттэй хаалганы өдрийг тохиолдуулан эх оронч үзэл, хүмүүжлийг түгээн дэлгэрүүлж, хүнлэг, энэрэнгүй нийгмийг цогцлоох зорилгоор "Монгол цэргийн нэгдсэн холбоо", Хэнтий аймгийн цэргийн штаб, Дэлгэрхаан сумын Засаг даргын Тамгын газар хамтран ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад сургалтыг зохион байгууллаа.

Уг арга хэмжээнд Зэвсэгт хүчний 232 дугаар ангийн захирагч хурандаа Н.Мягмарцоож, Монгол цэргийн нэгдсэн холбооны удирдах зөвлөлийн гишүүн, Монгол Улсын ШУ-ны гавьяат зүтгэлтэн, доктор профессор, хошууч генерал Н.Жалбажав, МЦНХ-ны ажлын албаны дарга, бэлтгэл хурандаа Ж.Ванчинсүрэн, ажлын албаны ажилтан, Монгол улсын гавьяат хуульч, цагдаагийн бэлтгэл хурандаа Ж.Бумнанжид, Удирдах зөвлөлийн гишүүн, Монгол улсын соёлын гавьяат зүтгэлтэн, доктор Ж.Цогтсугар, "Мөнх дурсагдах

баатрууд" Төрийн бус байгууллагын тэргүүн, доктор, профессо бэлтгэл хурандаа Ж.Өвгөнбүрд, Хэнтий аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, хурандаа Н.Хүрлээ, МЦНХ-ны Хэнтий аймаг дахь салбар холбооны нарийн бичгийн дарга, бэлтгэл дэд хурандаа Ц.Батсайхан нар илтгэл хэлэлцүүлсэн юм.

Тус арга хэмжээний үеэр хүрэлцэн ирсэн зочдод 1939, 1945 оны Халхын голын Чөлөөлөх дайнд ашиглаж байсан зэвсэг, одон медаль болон Хөдөлмөрийн баатар, маршал Ю.Цэдэнбал тэргүүтэй БНМАУ-ын баатруудын уран баримал зэрэг үзэсгэлэнг дэлгэн сонирхууллаа.

Мөн Хэнтий аймгийн Цэргийн штабын алба хаагчид Хэнтий аймгаас хоёрдугаар ээлжээр татагдан ирсэн хугацаат цэргийн алба хаагчдад гарын бэлэг гардуулан, дурсгалын зураг татуулж цэргийн албаа нэр төртэй хаахад нь амжилт хүсэж, баяр хүргэсэн юм.

Ахмад С.ОЧИРБАТ

Сургалт

МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №32

3 НГ ДЭВСГЭРИЙГ ЗӨВ, ЦЭВЭР БИЧИХ /үргэлжлэл/

Үгийн дунд ямар үгэнд НГ дэвсгэр ордгийг өмнөх хичээлээр тайлбарласан. Одоо тэдгээр жишээг монгол бичгээр нь бичиж үзье. *Жич: Э-гийн дараа орсон НГ-ийг шүдний зай авч, А-гаас ялгаж бичдэг.*

Дармал, бичмэл тигээр:

Handwritten examples of Mongolian script showing the use of the 'НГ' (ng) sign in various contexts, including vertical and horizontal writing styles.

Сургалт

**СҮХБААТАРЫН БА БАЙЛДААНЫ БОЛОН ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТҮГИЙН ОДОНТ ЖАНЖИН Д.СҮХБААТАРЫН НЭРЭМЖИТ ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛЬ**

**2022-2023 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ӨВЛИЙН УЛИРЛЫН МАГИСТР ДОКТОРЫН ЭЛСЭЛТ**

**ЭЛСЭЛТ АВАХ ХӨТӨЛБӨР, МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛ:**

**МАГИСТРЫН ХӨТӨЛБӨР**

1. Хуурай замын цэргийн сургалт
2. Агаарын цэргийн сургалт
3. Батлан хамгаалах
4. Цэргийн шинжлэх ухаан
5. Аюулгүй байдал судлал
6. Төрийн удирдлага

**ДОКТОРЫН ХӨТӨЛБӨР**

1. Батлан хамгаалах
2. Цэргийн шинжлэх ухаан
3. Аюулгүй байдал судлал

Бүртгэл: 2022.12.07-оос 2023.01.24-ний ажлын өдрүүдэд 09.00-17.00 цагт ҮБХИС хичээлийн I байр, 205, 211 тоотод бүртгэж байна.  
Шалгалт: 2023.01.25 -нд  
Холбоо барих: 88286325, 86100101, 99092890  
E-mail: [lhbatjarqal@gmail.com](mailto:lhbatjarqal@gmail.com), [sbolortsetseg22@gmail.com](mailto:sbolortsetseg22@gmail.com)